



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2022 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 120

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 4, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.2, 3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль (бүрэлдэхүүн сургууль, салбар, нэгж)-ийн албан хэрэгцээнд зориулан өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр 2022 онд нийт 4,869,243,185.70 (дөрвөн тэрбум найман зуун жаран есөн сая хоёр зуун дөчин гурван мянган нэг зуун наян таван төгрөг далан мөнгө) төгрөгт багтаан үл хөдлөх хөрөнгө олж авахыг зөвшөөрч, санхүүжилтийн дүн, үнийн дээд хязгаарыг хавсралтаар баталсугай.

2.Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн захирал Н.Хүрэлбаатарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай

2.1.Үндсэн худалдан авах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА *Д. Нарангэрэл* Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2022 оны 9 дугаар сарын 9-ны өдрийн
 20 дугаар тогтоолын хавсралт

**АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ИХ СУРГУУЛИЙН (БҮРЭЛДЭХҮҮН СУРГУУЛЬ, НЭГЖ)-ИЙН
 ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭР 2022 ОНД ОЛЖ АВАХ ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Эргэлтийн бус хөрөнгийн төрөл, нэр	Хэмжих нэгж, тоо хэмжээ	Барьж эхэлсэн (эхлэх) он	Нийт төсөвт өртөг (төгрөг)	2022 онд зарцуулах санхүүжилтийн дүн (төгрөг)
1	Эрдмийн сургуулийн өргөтгөлийн барилга угсралтын ажил	1ш	2021	1,200,000,000.00	1,200,000,000.00
Барилга байгууламж АШУҮИС-ийн дүн				1,200,000,000.00	1,200,000,000.00
2	100 ортой Эрхэс сувиллын барилга угсралтын ажил	1ш	2022	6,252,099,840.00	2,074,243,185.70
Барилга байгууламж Эрхэс сувилалын дүн				6,252,099,840.00	2,074,243,185.70
3	Төв эмнэлгийн 5 болон 6 давхарын 14 айлын 600 м2 байрыг худалдан авах	600 М2	2022	1,500,000,000.00	1,500,000,000.00
Барилга байгууламж АШУҮИС-ийн төв эмнэлгийн дүн				1,500,000,000.00	1,500,000,000.00
4	100 ортой эрхэс сувиллын барилгын зураг төсөв /Гадна инженерийн шугам сүлжээний иж бүрэн/	1ш	-	95,000,000.00	95,000,000.00
Зураг төсвийн ажлын дүн				95,000,000.00	95,000,000.00
Нийт дүн					4,869,243,185.70 (дөрвөн тэрбум найман зуун жаран есөн сая хоёр зуун дөчин гурван мянган нэг зуун наян таван төгрөг далан мөнгө)